

хүндэвтэр хэлбэр 12,5%, харин 3-р бүлэгт нэн хүнд хэлбэр 25%, хүнд хэлбэр 15% байсан. Нэн хүнд хэлбэрийн тохиолдол нь зөвхөн цочмог В вирусийн халдвартай байсан. Эмнэлзүйн шинж тэмдэгийн

	HBsAg(+), anti-HAV(+), anti-HBcIgM(-)	HBsAg(+), anti-HAV-IgM(+), anti-HBcIgM(+)	HBsAg(+), anti-HAV-IgM(-), anti-HBcIgM(+)
Хордлого үргэлжилсэн хугацаа	4 өдөр	6 өдөр	7 өдөр
Шарлалт үргэлжилсэн хугацаа	7 өдөр	11 өдөр	12 өдөр
АЛАТ хэвийн болсон	20.2 өдөр	24.6 өдөр	33.4 өдөр

явцыг бүлгүүдээс нь хамааруулан хүснэгтэнд үзүүлэв

Дүгнэлт: HBsAg илэрсэн хүүхдүүдэд цочмог А вирусийн халдварын шарлалттай хэлбэр нь цочмог А вирус хепатитын адил хөнгөн хэлбэрээр явагдаж байна.

Халдвартай хэлбэрийн сүрьеэгийн өвчлөлийн судалгаа

*П. Нямхишиг, Х. Одсүрэн, Д.Долгормаа, Х. Давааням, М. Нансалмаа
Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв*

Монгол улсад жилд 10000 хүн амд тутамд 217 хүн сүрьеэ өвчнөөр шинээр өвчилж байна. Хүүхдийн сүрьеэгийн тасагт хэвтэн эмчлүүлэгчдийн дотор халдвартай хэлбэрийн сүрьеэ, олон эмийн дасалтай сүрьеэ (ОЭДС)—ийн өвчлөл нэмэгдэж байгаа нь сэтгэл эмзэглүүлсэн асуудал болж байна. Сүүлийн 3 жилд нийт 731 хүүхэд хэвтэн эмчлүүлснээс 19.2% (140) хүүхэд ХТН/+ сүрьеэгээр өвчилсөн байна.

Зорилго: Хүүхдийн сүрьеэгийн тасагт хэвтэн эмчлүүлэгчдийн дундах хүчилд тэсвэртэй нян эерэг (/ХТН/+) сүрьеэ, ОЭДС-н өвчлөл, цэрний түрхэцийн шинжилгээнд хүчилд тэсвэртэй нян эерэгээс сөрөгт шилжих хувь, ОЭДС-р өвчилсөн хувийг тодорхойлох, өвчлөлд нөлөөлж буй зарим шалтгааныг судлах.

Материал, арга зүй: 2005-2007 онд ХӨСҮТ-ийн хүүхдийн сүрьеэгийн тасагт хэвтэн эмчлүүлэгчдийн бүртгэлд эргэмж судалгааг хийв.

Үр дүн: Хүүхдийн сүрьеэгийн тасагт 2005 онд 255 хүүхэд хэвтэн эмчлүүлсний 16.5%(42), 2006 онд 218 хүүхэд хэвтэн эмчлүүлсний 19.7% (43), 2007 онд 258 хүүхэд хэвтэж эмчлүүлсний 21.3% (55) нь тус тус ХТН/+ сүрьеэгээр өвчилсөн байв. Эмчлүүлэгчдийг насны бүлгээр үзэхэд 0-5 насныхан 19.6% (143), 6-10 нас -18.3%, (136), 11-15 нас-46.6% (343), 16-18 насныхан 15.5% (114)-ийг тус тус эзэлж байна.

ХТН/+ сүрьеэгээр өвчлөгсөдийн дотор 0-5 насныхан 0% , 6-10 насныхан 7.8% (80), 11-15 насныхан 52.1%(73), 16-18 насныхан 31.4%(51) байна. ХТН /+ / сүрьеэгээр өвчлөгсөдийг хүйсийн байдлаар авч үзвэл: 2005 онд эмэгтэй 24(57.2%), эрэгтэй 18 (42.8%), 2006 онд эмэгтэй 24(55.8%), эрэгтэй 19 (44.2%), 2007 онд эмэгтэй 31(56.2%), эр 24(45.6%) байна. Хүүхдийн сүрьеэгийн тасагт 2 дахь сардаа хэвтэн эмчлүүлэгсэдийн цэрний түрхэцийн 140 шинжилгээгээр ХТН /+/ гарсан тохиолдлолын цэрийг өсгөвөрлөхөд өгөхөд 16 (2006онд - 4, 2007 онд 12) нь эмийн дасалтай болох нь батлагдсан. Үүнээс 12 хүүхэд ОЭДС-н эмчилгээнд хамрагдаж эдгэрч гарсан ба 4 хүүхэд нас барсан.

Дүгнэлт:

1. Уушгины хэлбэрийн түрхэц эерэг сүрьеэгээр өвдсөн хүүхдүүдийн цэрний түрхэцийн шинжилгээнд хүчилд тэсвэртэй нян эерэгээс сөрөгт шилжих хувь багасч байгаа нь хүүхэд хүндэрсэн үедээ оношлогдож байгаатай холбоотой байна.
2. Уушигны хэлбэрийн түрхэц эерэг сүрьеэгээр өвдсөн хүүхдүүдийн дотор 11-18 насны эмэгтэй хүүхэд зонхилон өвчилж байна.
3. Хүүхдүүдийн дунд ОЭДС-н өвчлөл нас баралт жил ирэх тусам нэмэгдэж байна.

Цээжний хөндийн идээт үрэвсэлийн үүсгэгч, түүний антибиотик мэдрэг чанарыг судалсан нь

*О.Жавзандулам Х. Эрдэнэцэцэг
Э. Сүхээ, Ж. Алтанбагана
Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв*

ХӨСҮТ-ийн мэс заслын тасагт 2005–2009 оны хооронд цээжний хөндийн идээт үрэвсэл оноштойгоор нийт 155 эмчлүүлэгч хэвтэж эмчлүүлсэнээс мэс засал эмчилгээг 102 тохиолдолд хийсэн байна. Энэ нь сүүлийн 4 жилд хийсэн мэс засал эмчилгээний 6% -г эзлэж байна. 2005-2009 оны хооронд цээжний хөндийн идээт үрэвсэлээр өвчилсөн тохиолдлоудын өвчний түүхэнд судалгаа хийж үзэхэд 155 тохиолдолоос 6 (3%) нь нас барсан, 102 (65,8%) нь мэс засал эмчилгээ хийлгэсэн байна. Эдгээр мэс засал хийлгэсэн өвчтөнүүдэд хагалгааны өмнө болон дараа өргөн хүрээний антибиотикүүдыг сонгон хэргэлсэн боловч цээжний хөндийн идээнд бактериологи шинжилгээ хийж эмгэг төрүүлэгч нянг илрүүлээгүй, эмгэг төрүүлэгч нянгын антибиотик мэдрэг чанарыг үзэж тохирсон антибиотикүүдыг сонгон авч хэргэлсэн тохиолдол таарсангүй.

Зорилго: Цээжний хөндийн идээт үрэвслийг зонхилон үүсгэх эмгэгтөрөгч нян, тэдгээрийн мэдрэг